Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний 2 дугаар хавсралт

# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

**2022.12.08**

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Зарцуул сан хөрөнгө | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт хүрээгүй бол тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| **Хот байгуулалтын чиглэлээр** | | | | | | |
| 1 | “Монгол Улсын Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулахад шаардлагатай мэдээ, мэдээллээр тухай бүр хангах, уг төслийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах | - | Ажлын хэсэг байгуулах тушаал 1, хурал зохион байгуулах 1 | Хэлэлцүүлгийн агуулга оновчтой, холбогдох талуудыг бүрэн хамруулсан байх | Хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох мэдээллээр хангасан байна. | Тус аймагт төслийн баг 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр ажиллаж хот байгуулалт, нийгмийн хөгжил, хөдөө аж ахуй, байгаль орчин, бизнесийн орчны асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт аймгийн Засаг даргын тамгын газар болон харьяа агентлаг, байгууллагын төлөөллүүд оролцож, шаардлагатай мэдээ, мэдээлэл цуглуулахад хамтран ажилласан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 2 | Аймаг, сумдын барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж инженерийн дэд бүтцийн өгөгдлийн санг бүрдүүлэх, хот байгуулалтын кадастрын мэдээллийн нэгдсэн системийн нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт | - | Нэгдсэн мэдээллийн сан | Холбогдох хууль, дүрэм, журмын шаардлага хангасан байна. | Аймгийн хэмжээнд барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн өгөгдлийн санг үе шаттайгаар бүрдүүлж, хот байгуулалтын кадастрын мэдээллийн нэгдсэн системийн | Орон нутгийн төсвийн 150,0 сая төгрөгөөр “Дундговь аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлж, мэдээллийн санд бүртгэх” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд аймгийн төвөөс бусад 14 сумын төвийн 2392 барилга байгууламж, 204.14км |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хийж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг ГЗБГЗЗГ-тай хамтран хэрэгжүүлэх | | | | нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийгдэн хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ болон 823.143м2 зам талбай, 1230 тохижилт ногоон байгууламжийн мэдээллийг бүрдүүлэн Хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх ажлыг ГЗБГЗЗГ-тай хамтран зохион байгуулсан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 3 | Бүсийн тулгуур төв, аймгийн төв хотууд болон сумын төвийн батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний “Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, тайлагнах | - | Аймгийн хэмжээнд | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан байна. | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 12 дугаар хуралдаанаар Баянжаргалан, Өндөршил, Луус, Хулд сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэж хүлээн авсан. Дээрх сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний “Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулсан. Тус оны 12 дугаар сард сумдын ИТХ-аар батлуулна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 4 | Хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөний тоон баримт бичгийг хот байгуулалтын мэдээллийн санд оруулах, солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлыг ГЗБГЗЗГ-тай хамтран зохион байгуулах | - | Аймгийн хэмжээнд | Холбогдох хууль тогтоомжийн дагуу, мэдээллийн сангийн бүрдлийг хангасан байх. Мэдээлэл бодит үнэн байх | Батлагдсан баримт бичгийг бүрэн хамруулсан байна. | Хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөөний тоон баримт бичгийг хот байгуулалтын мэдээллийн санд оруулах, солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд тус аймгийн 15 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний судалгааг гаргаж, ГХБХБГ-ын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 1/394 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Тус |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судалгаагаар батлагдсан ерөнхий төлөвлөгөөтэй 7 сум, шинээр боловсруулагдаж байгаа 7 сум, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй 1 сум байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 5 | “Хот байгуулалтын тухай” хууль болон холбогдох дүрэм, журмын дагуу орон нутгийн захиалгаар хийгдэх хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын зургийн даалгаврыг ГЗБГЗЗГ-аар хянуулан, баталгаажуулж байх. | - | Ажлын болон зургийн даалгаврын тоо | Холбогдох хууль, норм стандартын дагуу хийгдсэн байна<br>. | Ажлын болон зургийн даалгаврыг хянуулсан байна. | Тус аймгийн Эрдэнэдалай сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврыг ГЗБГЗЗГ-аар, Цагаан суваргын аялал жуулчлалын бүсийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврыг БХБЯ болон ГЗБГЗЗГ-ын холбогдох албан тушаалтнуудаар тус тус хянуулан аймгийн Засаг даргаар батлуулан захиалагч байгууллагад хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 6 | Орон нутгийн болон хувь хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтөлж, тайланг хагас, бүтэн жилээр ГЗБГЗЗГ-т хүргүүлэх | - | 2 удаа | Бүртгэлд мэдээлэл бүрийг хамруулах | Бүртгэл хөтөлж тайланг тухай бүр ирүүлнэ. | Орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжийн нэгдсэн бүртгэлийг хөтөлж, явцын мэдээг хагас, бүтэн жилийн байдлаар ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 16, хувийн хөрөнгө оруулалтаар 6 төсөл арга хэмжээ бүртгэгдсэн байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 7 | Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг уялдуулан аймаг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, мөрдөж ажиллах. | - | 1 | Тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь ХЕТ-тэй уялдсан байна. | 2 төлөвлөгөө уялдсан байна. | 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа аймаг, сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уядуулан боловсруулсан.<br><br>**Хэрэгжилт: 100 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | Аймгийн ерөнхий архитекторын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажлын үр дүнг бүтэн жилээр үнэлэн ГЗБГЗЗГ-т хүргүүлэх | - | 1 удаа | Холбогдох хууль, дүрмийн дагуу хийгдсэн байх | Үйл ажиллагааг үнэлж ирүүлсэн байна. | Аймгийн Ерөнхий архитекторын 2021 оны үйл ажиллагааны тайланг ГХБХБГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 3/14 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Тус тайлангийн хэрэгжилт 84,75 хувьтай үнэлэгдсэн бөгөөд улсын дундажаас 0,27 хувийн өсөлттэй байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 9 | Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу дахин төлөвлөлтийн төсөл, арга хэмжээг санаачлан хэрэгжүүлэх, санал зөвлөмж авч ажиллах | - | Төсөл, арга хэмжээний дагуу хийгдсэн байх | Холбогдох хууль тогтоомжийн дагуу | Төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байх | Тус хуулийн 12.1.2 /Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих/ заалтын дагуу Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэг, 3-р сургуулийн барилгыг буулган шинээр барихаар улсын төсөвт хөрөнгө оруулалтыг тусгуулсан бөгөөд дээрх 2 барилгын буулгалтын ажил хийгдсэн, он дамжин хэрэгжинэ. Мөн хуулийн 12.1.5 /Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах/ заалтын дагуу 2022 оны улсын төсвийн 1,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайнцагаан суманд Гудамж талбайн тохижилт, ногоон байгууламжийн ажлыг “Тэнгисийн шүр” ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулан, зураг төслийг “Онч тэнхлэг” ХХК боловсруулан батлуулсан. Мөн аймгийн төвийн Айраг багийн 9-р гудамжны дэд бүтцийн тохижилтын ажлыг ОНХС- |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ийн 199,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Дундговь-Ус” ОНӨҮГ гүйцэтгэж байна. Мөн ОНХС-ийн 289,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвийн гэр хорооллуудад жишиг хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажил 3 байршилд хийгдсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 10 | Монгол Улсын Үндсэн хууль, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулинд нийцүүлэн хот, суурин газарт улс, орон нутгийн зэрэглэл тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд шаардлагатай судалгаа, тооцоог гаргаж холбогдох газарт хүргүүлэх | - | Аймгийн хэмжээний судалгаа, тооцоо | Холбогдох хууль тогтоомжийн дагуу | Шаардлагатай судалгаа, тооцоог гаргаж ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна. | Хот, суурин газарт улс, орон нутгийн зэрэглэл тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд шаардлагатай нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн талаарх мэдээлэл тусгасан 21 төрлийн судалгаа, тооцоог гаргаж ГХБХБГ-ын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 1/447 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 11 | Сумдын барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн дэд бүтэц болон нийгмийн дэд бүтцийн мэдээллийг бүрдүүлэх хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах | - | Аймгийн хэмжээнд | Холбогдох хууль, дүрэм, журам, зааврын шаардлага хангасан байна. | Аймгийн хэмжээнд барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, нийгмийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламжийн мэдээллийг Хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэсэн байна. | “Дундговь аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлж, мэдээллийн санд бүртгэх” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд мэдээллийн санд зурагдсан өөрчлөлт ороогүй 460 барилга, 307 ногоон байгууламж, 751855м.кв зам, 358 байршилд 64908м.кв нийтийн эзэмшлийн талбай, 45 байршилд 6380м.кв авто зогсоол, 863 ширхэг гудамж талбайн гэрэлтүүлэг, 15 ширхэг усан оргилуур, 45 ширхэг хөшөө дурсгал, зурагдаагүй 2184 барилга, инженерийн дэд бүтэц, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 20,9 км дулаан хангамжийн шугам, 21,19 км ариутгах татуургын шугам, 655 ширхэг цооног, 18,83 км ус хангамжийн шугам, 149,22км цахилгаан хангамжийн шугам, 3281 ширхэг тулгуур, 48 дэд станцын зураглал болон мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 12 | Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг Хот байгуулалтын кадастрын цахим системээр олгох ажлыг зохион байгуулах | - | Аймгийн хэмжээнд | Холбогдох хууль, тогтоомжийн дагуу | Аймгийн хэмжээнд барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг Хот байгуулалтын кадастрын цахим системээр олгосон байна. | 2022 оны жилийн эцсийн байдлаар 29 барилга байгууламж, засварын ажилд шинээр барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг хот байгуулалтын кадастрын системээр олгосон. Ашиглалтад орсон болон зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээллийг Барилга, хот байгуулалтын сайдын 55 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу гаргаж ГХБХБГ-ын 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 1/336 тоот албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 13 | “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Газрын тухай хууль, Хот байгуулалтын | - | Тохижилт, цэцэрлэгжүүлэлт хийсэн гудамж, талбайн хэмжээ | Байгаль экологийн тэнцвэртэй байдал, агаарын чанар, хүний ая тухтай байдлыг хангасан байх | Төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, гудамж, талбайг тохижилтыг сайжруулах, цэцэрлэгжүүлэх, цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг хэрэгжүүлсэн байна. | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд мод үржүүлгийн зориулалтаар 9 сумандаа 104.33га, мод тарих зориулалтаар 14 суманд 750.91 га газрыг 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тухай хуульд заасан хувь хэмжээгээр аймаг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах, мод үржүүлгийн зориулалтаар газар эзэмшүүлэх ажлыг дэмжиж ажиллах" арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх | | | | | Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, "Дундговио ногооруулъя" хөтөлбөрийн хүрээнд "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг 2 удаа зохион байгуулж, 1053 өрх, 147 аж ахуйн нэгж, байгууллагын 5690 иргэнийг хамруулан мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, нийт 122884 мод, сөөг тарьж ургуулж байна. Дээрх ажилд улсын төсвөөс 90.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 122.0 сая төгрөг, хувийн хэвшлийн хөрөнгөөр 116.3 сая төгрөг тус тус зарцуулсан байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| **Газар зохион байгуулалт, газрын харилцааны чиглэлээр** | | | | | | |
| 14 | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | | Аймгийн хэмжээнд | Холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу | Засаг даргын харьяа агентлагуудыг оролцуулан Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг харилцан уялдаатайгаар зохион байгуулж, хэрэгжилтийг БХБЯ-нд ирүүлсэн байна. | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдээс 2022 онд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд 25 худаг шинээр гаргаж, 32 худаг засварласан. Сайнцагаан суманд 15,3 га газарт хамгаалалтын ойн зурвас байгуулсан. 15 сумын суурин газрын суурьшлын бүс буюу эдэлбэр газрын хил заагийг шинэчлэн тогтоож .shp файлыг ГЗБГЗЗГ-ын мэргэжилтэн Р.Отгончимэгт цахимаар хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ГХБХБГ-ын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1/458 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хэрэгжилт: 100 хувь** |
| 15 | 2022 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын талаар гарсан Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | | Аймгийн хэмжээнд | Холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу | Засгийн газрын тогтоол хэрэгжиж хэрэгжилтийг 2022 оны 12 сарын 20-ны дотор Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх. | 2022 онд аймгийн хэмжээнд нийт 1452 иргэнд 111,86 га газар өмчлүүлэхээр төлөвлөснөөс 1045 иргэнээс газар өмчлөх хүсэлт ирж, өргөдлийг бүрэн шийдвэрлэсэн. Тогтоолын хэрэгжилтийг гаргаж 2022 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн 1/451 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 16 | Аймаг, нийслэлийн хэмжээнд 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг тогтоож аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах | | Аймгийн хэмжээнд | Холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу | Аймаг, нийслэлийн хэмжээнд 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг тогтоож аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж 2022 оны 10 сарын 15-ны дотор багтаан Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байна. | 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 41 тоот тогтоолоор батлуулж тогтоолыг ГХБХБГ-ын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 2/323 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 17 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэх талаар сумын Засаг дарга нартай хамтран ажиллаж шийдвэрлэх | | Аймгийн хэмжээнд | Холбогдох хууль тогтоомж, стандартын хүрээнд | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай төсөв, хөрөнгийг орон нутгийн төсөвт суулгасан байна. | Тус аймгийн 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг 2018 онд бүрэн хийлгүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 18 | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг | | Тухай бүр | Холбогдох хууль | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авахад | Адаацаг сумын 4-р багт байршилтай Сүм хөх бүрдийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах | | | тогтоомжийн дагуу | шаардлагатай арга хэмжээг орон нутагт зохион байгуулж, БХБЯ, бусад байгууллагатай хамтран ажилласан байна. | орчны газрыг улсын тусгай хэрэгцээнд авахаар 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган аймгийн ИТХ-аар хэлэлцүүлсэн. Улсын тусгай хамгаалалтад авах саналыг БОАЖ-ын сайдад хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 19 | Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох, шилжүүлэх,цуцлах болон тэдгээрийг улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд бүртгэх ажлыг Газрын кадастрын нэгдсэн цахим системээр дамжуулан шийдвэрлэх | | Аймгийн хэмжээнд | Тухайн жил Засаг даргын шийдвэрээр олгосон, шилжүүлсэн, цуцалсан бүх газрын эрхийн мэдээлэл газрын кадастрын нэгдсэн цахим системд бүртгэгдсэн байх | Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт нэгж талбарын мэдээлэл газрын кадастрын нэгдсэн цахим системд баталгаажиж, улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд бүртгэгдсэн байна. | Газрын кадастрын цахим системд нийт 1971 өргөдлийг бүртгэж шийдвэрлэлээ. Үүнд: шинээр газар өмчлөх 1045 иргэнд 77.59 га, шинээр газар эзэмших 285 иргэн, хуулийн этгээдэд 1473.1 га, газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх 190 иргэн, хуулийн этгээдэд 60.96 га, шинээр газар ашиглах 7 ААН-д 968154.96 га газрыг цахим системд бүртгэж баталгаажуулсан. Мөн газар эзэмших эрхээ цуцлах хүсэлт гаргасан болон 2 жил ашиглаагүй 15 иргэн, хуулийн этгээдийн 4.42 га газрын эзэмших эрхийг аймгийн Засаг даргын захирамжаар цуцалж, мэдээллийн санд дуусгавар болгосон. 61 иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхээ барьцаалах хүсэлтийг мэдээллийн санд бүртгэсэн. Улсын бүртгэлийн дундын мэдээллийн сангаас 390 иргэн, хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтын газар дээр улсын бүртгэлийн “Э” “А” дугаарыг авч газар эзэмших, ашиглах цахим |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэрээ гэрчилгээг үүсгэсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 20 | Төрийн өмчийн газрын хариуцагчтай гэрээ байгуулж, гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллах | | Аймгийн хэмжээнд | Төрийн өмчийн газрын хариуцагчтай гэрээ байгуулж, гэрээний үүргийн биелэлт хангагдсан байна. | Төрийн өмчийн газрын хариуцагчтай гэрээ байгуулж, гэрээг мэдээллийн санд баталгаажуулсан байна. | Газрын нэгдмэл сангийн цахим системд Төрийн өмчийн газрын хариуцагч аймаг, сумдын Засаг дарга нарын мэдээллийг бүртгэж, төрийн өмчийн газрын хариуцагчтай гэрээг байгуулан хэрэгжүүлж ажилласан. Төрийн өмчийн газрын тооллого явагдаж аймгийн хэмжээнд 266 төрийн болон орон нутгийн өмчийн газрыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж, цахимаар гэрээ, гэрчилгээг үүсгэн, цаасан болон цахим архивыг үүсгэсэн. **Хэрэгжилт:100 хувь** |
| 21 | Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу гудамж, зам, талбай, нэгж талбар, барилга байгууламжийн хаягийн мэдээллийг засварлах, шинээр хаяг олгох үйл ажиллагааг хаягийн мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан эрхлэх | | Аймгийн хэмжээнд | Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, эд хөрөнгийг хаягжуулах журам”-ын дагуу гудамж, зам, талбай, нэгж талбар, барилга байгууламжийг хаягжуулах | Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээн дэх нийт гудамж, зам, талбай, нэгж талбар, барилга байгууламжид хаягийн мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан хаяг олгосон байна. | Аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг шинэчлэх, засварлах ажил хийгдэж дууссан ба иргэн, аж ахуй нэгж, байгууллагын мэдээг хаягийн мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан газрын кадастрын мэдээллийн санд 136 иргэн, 45 аж ахуй нэгж, 23 байгууллагын хаягийг баталгаажуулаад байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 22 | Нэр олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх ажлыг зохион байгуулж | | Аймгийн хэмжээнд | Засгийн газрын 2019 оны 325 дугаар | Гудамж, зам, талбай нь нэршил ИТХ-ын тогтоолоор | Сайнцагаан сумын ИТХ-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 42 тоот тогтоол, 2021 оны 12 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ИТХ-ын тогтоолоор баталгаажуулах | | | тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, эд хөрөнгийг хаягжуулах журам”-ын дагуу гудамж, замыг нэрлэх | баталгаажсан байна. | дугаар сарын 02-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор тус тус гудамж, зам талбайд нэр өгч хаягийн мэдээллийн санд баталгаажуулсан.<br>2022 онд шинээр гудамж зам талбай нэмэгдээгүй байна.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 23 | Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг Газрын биржийн цахим системээр дамжуулан цахим хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээ авах | | Аймгийн хэмжээнд | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбарын тоогоор дуудлага худалдаа зохион байгуулагдсан байна. | Тухайн жилийн төлөвлөгөөгөөр батлагдсан газарт дуудлага худалдаа зохион байгуулсан байна. | Сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар олгохоор тусгагдсан 56 байршилд 78 удаа дуудлага худалдааг цахимаар зохион байгуулснаас 22 дуудлага худалдааг дахин зарласан ба 26 дуудлага худалдаа амжилттай болж, 52 дуудлага худалдаа үнэ төлөөгүй, оролцогчгүй зэрэг шалтгааны улмаас хүчингүй болсон.<br>Танхимаар дуудлага худалдаа зохион байгуулаагүй.<br>Аймгийн хэмжээнд 9 байршилд салхин сэнсний судалгааны талбайн зориулалтаар төсөл сонгон шалгаруулалтыг Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын дагуу зохион байгуулж, гэрээг байгуулан тухайн сумын Засаг даргын захирамжаар газар ашиглуулах ажлыг зохион байгуулсан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 24 | Газрын биржийн цахим програм хангамжаар | | Аймгийн хэмжээнд | Газар өмчлөх, эзэмших эрх | Газар өмчлөх, эзэмших эрх шилжсэн тоогоор | Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээний |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 25 | дамжуулан газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах, олон нийтэд үйлчлэх үйл ажиллагаанд дэмжлэг болж ажиллах | | | шилжсэн тоогоор үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулсан байна. | үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулж дүн шинжилгээ хийж, олон нийтэд үйлчилгээ үзүүлсэн байна. | худалдагдсан үнийг газар эзэмших, өмчлөх эрх шилжсэн тоогоор, санал болгож буй үнийг зарын дагуу судлан тухай бүр цахим биржид бүртгэсэн. 2022 онд Сайнцагаан сум 270, Эрдэнэдалай сум 23, Дэрэн сум 3, Өндөршил сум 6, Адаацаг 1, Дэлгэрцогт 8, Хулд 1, Гурвансайхан 2, Баянжаргалан 3 нийт 317 үнийн мэдээг цахим биржид тухай бүр бүртгэн олон нийтэд нээлттэй мэдээлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 25 | Газрын биржийн тусгай дансанд дуудлага худалдааны орлого болон дэнчинг төвлөрүүлэн зарцуулах нөхцөлийг бүрдүүлэн гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах | | Аймгийн хэмжээнд | Дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэн зарцуулах нөхцөлийг бүрдүүлэн гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан байна. | Газрын биржийн тусгай дансанд дуудлага худалдааны орлого болон дэнчинг төвлөрүүлсэн байна. | Тус аймгийн дуудлага худалдааны орлогын дансанд (100080000967 Ду.Газрын дуудлага худалдааны орлого) газрын дуудлага худалдааны орлого, дэнчин, газрын суурь үнийг төвлөрүүлдэг. Газрын дуудлага худалдаа, газрын суурь үнийн орлого 88 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээс газрын дуудлага худалдаанаас 74,8 сая төгрөг, газрын суурь үнэ 83,0 сая төгрөг, нийт 157,8 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 26 | Засаг даргын шийдвэрээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгогдсон нийт нэгж талбарт газрын төлбөр, татварыг Газрын төлбөр, татварын нэгдсэн цахим системээр дамжуулан бүрэн ногдуулах | | Аймгийн хэмжээнд | Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол,сум дүүргийн ИТХ-аар баталсан газрын үнэлгээний | Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд Засаг даргын шийдвэрээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгогдсон нийт нэгж талбарт газрын төлбөр, | ГЗБГЗЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 1/194 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн хэмжээнд 6838 нэгж талбарын 2022 оны газрын төлбөрийн нэхэмжлэлийг сумдын ИТХ-аас 2018 онд тогтоосон итгэлцүүрийн дагуу хуулийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулах | | | зэрэглэл /бүс/-ийн газрын төлбөр тооцох итгэлцүүрт үндэслэсэн байх | татварыг бүрэн ногдуулсан байна. | хугацаанд үүсгэн газрын төлбөрийг төвлөрүүлж байна. 2022 онд аймгийн хэмжээнд нийт 7081 нэгж талбарын ногдуулалтыг үүсгэж 6838 нэгж талбарын нэхэмжлэлийг үүсгэсэн. 1882 нэгж талбарын газрын төлбөрийн төлөлт бүртгэгдсэн байна. Татвар төлөгчөөр бүртгэгдээгүй, газар эзэмшигч нас барсан, регистрийн дугаар зөрүүтэй, ТИН дугаар бүртгэлгүй зэрэг шалтгааны улмаас 243 нэгж талбарын нэхэмжлэх үүсээгүй байна. 2022 онд газрын төлбөрийн орлого 362 сая төгрөг төвлөрүүлэхээс 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 450,574,900 төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 27 | Инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх ажлыг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах | | Аймгийн хэмжээнд | Инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн байна. | Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн байна. | Аймгийн хэмжээнд шилэн кабель 216.1 км, цахилгааны шугам сүлжээний 741.3 га газар, цэвэр усны шугам 26.9 км газрыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж баталгаажуулаад байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 28 | Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг | | Аймгийн хэмжээнд | Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолыг | Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон | Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтад нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан газрын төлбөр ногдуулах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах | | | үндэслэн батлагдсан тогтоолыг газрын төлбөр, татварын системд баталгаажуулсан байна. | утгыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан байна. | итгэлцүүрийг шинэчлэн тогтоох ажлыг Захиргааны ерөнхий тухай хуулийн дагуу зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 07 дугаар тогтоолоор тус аймгийн "Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр, төлбөрийн хэмжээ"-г батлуулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.<br>Уг тогтоолын дагуу аймгийн хэмжээнд хүчинтэй төлөвт байгаа нэгж талбарын газрын төлбөрийг шинэчлэн бодуулсан.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 29 | 1. Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Монгол хэлний тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Хаягжуулалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол болон уг тогтоолын хавсралтаар батлагдсан "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам"-ыг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, хаягийн зураг, хаягийн мэдээллийн санг нэгдсэн системд тогтмол шинэчлэх | | Биелэлтийн тайлан | Хаягжуулалтын тухай хууль, Геодези зураг зүйн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол, БХБ-ын сайдын 2020 оны 15 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажилласан байх | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нутаг дэвсгэртээ хамаарах хаягийн мэдээллийг бүрдүүлж мэдээллийн сан болон нэгдсэн системд оруулсан байна. | Аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг шинэчлэх, засварлах ажил хийгдэж дууссан ба иргэн, аж ахуй нэгж, байгууллагын мэдээг хаягийн мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан газрын кадастрын мэдээллийн санд 136 иргэн, 45 аж ахуй нэгж, 23 байгууллагын хаягийг баталгаажуулаад байна.<br>2018 онд аймгийн төвийн Аривжих, Боржигон, Нарлаг, Айраг, Мандал хорооллын 2694 хашааг стандартын дагуу шинээр хаягжуулсан. Үүнээс хойш Дэвжих хороолол болон шинээр нэмэгдсэн гудамж, барилга, хашааг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тогтолцоог бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбоотой арга хэмжээнүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, уг ажлын хүрээнд гарах төсөв, зардлыг 2022,2023 оны орон нутгийн төсөвт тусган ажиллах<br>2. БХБ-ын сайдын 2020 оны 15 дугаар тушаалаар баталсан "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө/2020-2023 он/"-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах. | | | | | хаягжуулахаар 490 хаягийн тэмдэгийг сумын ОНХС-ийн 8.462.000 төгрөгийн хөрөнгөөр хийлгүүлэн хүлээн авсан.<br><br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 30 | Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7-д заасан Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлыг аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн хийх ажлыг зохион байгуулах | | Аймгийн хэмжээнд | Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан "Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам"-ын дагуу | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бэлчээр, тариалан, хот тосгоны газруудад байнгын ажиглалтын мониторингийн цэгүүдэд газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн зохион байгуулсан байна. | Тус аймгийн орон нутгийн төсвөөс 50 сая төгрөгийн санхүүжилтээр 15 сумын хот тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгаа хийх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж, гүйцэтгэгчээр "Вектор Мэп" ХХК шалгарч, аймгийн ЗДТГ-тай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэж тайланг 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр хүлээлгэж өгсөн.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 31 | Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5-т | | Аймгийн хэмжээнд | Газрын даргын 2015 оны А/103 | Иргэн, хуулийн этгээдийн өмчилж, | 2022 онд нийт 57 нэгж талбарын газрын төлөв байдал, чанарын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | заасны дагуу хөрс, орчны бохирдол ихээр үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газарт газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавих | | иргэн, хуулийн этгээдэд өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулж буй захиалгат хянан баталгаа хийлгэх хуулийн хугацаа болсон нэгж талбарт | тушаалаар баталсан журам, 2017 оны А/268 тоот тушаалаар баталсан зааврын дагуу | эзэмшиж, ашиглаж буй газарт газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, газар ашиглалттай холбоотой өөрчлөлт, доройтлыг арилгуулах ажлыг зохион байгуулсан байна. | захиалгат хянан баталгааны дүгнэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч, хянан шалгаж дүгнэлтийг баталгаажуулсан.<br><br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 32 | Бэлчээрийн газрын өөрчлөлт, доройтлыг фото мониторингийн аргаах үнэлэх ажлыг тасралтгүй зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, ажлын үр дүнг орон нутгийн байгууллага, иргэд, олон нийт болон малчид, тариаланчдад хүргэж, үйл ажиллагаандаа ашиглахад удирдлага, чиглэлээр хангаж ажиллах | | Аймгийн хэмжээнд байгаа нийт фото мониторингийн цэгт | Газрын даргын 2015 оны А/103 тушаалаар баталсан журам, 2017 оны А/268 тоот тушаалаар баталсан зааврын дагуу | Бэлчээрийн газрын фото мониторингийн нийт цэгт 8 сарын эхний 10 хоногт хээрийн судалгааг хийж, боловсруулалтын ажлыг гүйцэтгэж, аймгийн хэмжээнд тайланг нэгтгэсэн байна. | Аймгийн хэмжээнд 15 сумын 233 цэгийн 6908382.55 га бэлчээрийн талбайд 2022 оны 08 дугаар сарын эхний 10 хоногт багтаан хээрийн хэмжилт боловсруулалтын ажлыг зохион байгуулж, үр дүнг нэгтгэн ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.<br>Мөн аймгийн 2022 оны бэлчээрийн өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлсэн ажлын тайланг сумдын ИТХ-аар хэлэлцүүлж, доройтсон газруудад нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээ авах талаар 2023 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган ажиллах талаар чиглэл хүргүүлсэн.<br>**Хэрэгжилт: 100** |
| 33 | Шинээр баригдахаар төлөвлөж буй барилга | | Батлагдсан зураг төслийн | Газар хөдлөлийн | Шинээр баригдахаар төлөвлөж буй барилга | 2022 оны жилийн эцсийн байдлаар олон нийт, иргэний |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгууламжийн зураг төсөлд Газар хөдлөлийн бичил мужлалын зургийг суурь мэдээлэл болгон ашиглах, одоо ашиглагдаж буй барилга байгууламжуудад биет үзлэг хийж, паспортжуулах | | тоогоор | бичил мужлалын зургийг үйл ажиллагаандаа тогтмол ашигладаг болсон байна | байгууламжийн зураг төсөлд Газар хөдлөлийн бичил мужлалын зургийг суурь мэдээлэл болгон ашиглах, одоо ашиглагдаж буй барилга байгууламжуудад биет үзлэг хийж, паспортжуулах ажлыг аймгийн төвийн хэмжээнд зохион байгуулах | зориулалттай 20 барилгын архитектур төлөвлөлтийн даалгаврыг холбогдох дүрмийн дагуу боловсруулж баталсан. Тус даалгаварт газар хөдлөлийн бичил мужлалын зургийг суурь мэдээлэл болгон ашиглаж байх талаар заалт тусгаж, 12 барилгын ажлын зургийг хянаж баталгаажуулсан.<br><br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| **Геодези зураг зүйн чиглэлээр** | | | | | | |
| 34 | Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.2 дахь заалтын дагуу улсын захиалга, даалгаврын хүрээнд хийгдэх геодези, зураг зүйн ажлын дараа жилийн захиалгыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор гаргаж өгөх | | Геодези, зураг зүйн ажлын дараа жилийн захиалгын жагсаалт | Геодези, зураг зүйн хуулийг хэрэгжүүлж ажилласан байх | Хуульд заасны дагуу улсын болон орон нутгийн төсөв хөрөнгө, гадаадын зээл тусламж болон техник туслалцааны хүрээнд хийгдэх геодези, зураг зүйн ажлын тоо хэмжээ, төсөв, орон зайн хамрах хүрээний талаарх мэдээллийг ирүүлснээр дараа жилийн төсвийн саналын төслийг боловсруулах нөхцөл бүрдсэн байна. | 2023 онд ОНХС-ийн 40 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдэх Баянжаргалан, Хулд сумдын газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажлын даалгаврыг батлуулсан.<br><br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 35 | Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.4.2 дахь заалтын дагуу Геодезийн | | | | | Аймгийн хэмжээний ДУА1, ДУА2 байнгын ажиллагаатай станцуудын тасралтгүй үйл ажиллагааг ханган ажилласан. 2022 оны 01 дүгээр сарын 01-ний |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байнгын цэг тэмдэгт, байнгын ажиллагаатай станцын хадгалалт, хамгаалалт бүрэн бүтэн байдалд хяналт тавих, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг | | | | | өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хооронд аймгийн хэмжээнд 3 удаагийн цахилгааны эх үүсвэрийн хязгаарлалтаас хамаарч 24 цаг тасалдсан.<br>Аймгийн төвийн ДУА1 станцын бодит агшны хэмжилтийн засварын хяналтыг 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр, 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр хийж хэмжилтийн үр дүнг \\192.168.20.24\ сервэрт холбогдох байршилд хүргүүлээд байна. Геодезийн цэг тэмдэгтийн тооллогын ажил явагдаж байна. 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хийж хэмжилтийн үр дүнг \\192.168.20.24\ серверт болон албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд буй 531 геодезийн байнгын цэг тэмдэгтийн тооллогыг зохион байгуулж үр дүнг орон зайн өгөгдлийн нэгдсэн сан геопорталд оруулсан.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 36 | Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.4.2 дахь заалтын дагуу нутаг дэвсгэртээ хамаарах том болон дунд масштабын байр зүйн зураг, зураг зүйн бүтээлд тусгагдах шинээр байгуулагдсан болон | | Гүйцэтгэлийн зураг /3 болон 4 хэмжээст байр зүйн зураг болон кадастрын бүртгэлийг хийхэд шаардлагата | Геодези зураг зүйн хуулийг хэрэгжүүлж ажилласан байх. | Том болон дунд масштабын байр зүйн зураг шинэчлэгдсэн байна. | 2022 онд 1:1000-ны масштабтай байр зүйн зурагт 106 хашаа, 1263 метр шилэн кабелийн шугам, 6 олон нийтийн барилга, 14 амины орон сууцны барилгын шинэчлэлтийг хөтлөн явуулаад байна. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн бүрдлийг хангах ажлын хүрээнд хийгдсэн агаарын ортофото зураг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | өөрчлөгдсөн объектын талаарх мэдээллийг хуульд заасан хугацаанд геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гүйцэтгэлийн зургийн хамт тайлагнан мэдээлэх. | | й/, том масштабын байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураг, нэгдсэн тайлан. | | | болон бусад холбогдох ажлуудаар хийгдсэн гүйцэтгэлийн зураглалын мэдээллийг үндэслэн Геопортал цахим системд аймгийн төвөөс бусад 14 сумын тохижилт ногоон байгууламжийн 307 ногоон байгууламж, 751855м2 зам, 358 байршилд 64908м2 талбай, 45 байршилд 6380м2 авто зогсоол, 863 ширхэг гудамж талбайн, гэрэлтүүлэг, 15 ширхэг усан оргилуур, 45 ширхэг хөшөө дурсгал, дулаан хангамжийн 20,9км шугам, ариутгах татуургын 21,19км 655 ширхэг цооног, ус хангамжийн 18,83км шугам, цахилгаан хангамжийн 149,22км шугам, 3281 ширхэг тулгуур, 48 дэд станцын зураглал, хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд зурагдаагүй 2184 барилга байгууламжийн зургийг шинэчлэн оруулсан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 37 | Нутаг дэвсгэрийн хэмжээнд Монгол Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан газар зүйн нэрийн хэрэглээнд хяналт тавих, тогтоолын 2 дахь хэсгийн 2 дахь заалтын дагуу аймгийн түвшинд газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг холбогдох байгууллагатай хамтран | | Газар зүйн нэрийн тодруулалт хийсэн сумын тоо салбар зөвлөлийн хуралдсан тоо | Геодези, зураг зүйн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан байх. | Орон нутгийн төсөвт Газар зүйн нэрийн тодруулалтын зардлыг тусгаж, ажлыг зохион байгуулах, нэрийн хэрэглээнд хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион | 2022 онд тус аймгийн Адаацаг, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Сайхан-Овоо, Цагаандэлгэр сумдын газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах ажлыг хийлгэхээр ОНХСангийн хөрөнгөд 72.0 сая төгрөгийн төсвийг батлуулсан.<br>Адаацаг 548, Дэлгэрцогт 405, Цагаандэлгэр 575, Эрдэнэдалай 637, Сайхан-Овоо 486, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах, холбогдон гарах төсөв, зардлыг 2022, 2023 оны орон нутгийн төсөвт тусган ажиллах, Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх. | | | | байгуулах, хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагад тайлагнасан байна. | Дэлгэрхангай 606 нийт 3257 газар зүйн нэр 2004 онд Улсын Их Хурлаар батлагдсан байсныг уг ажлын хүрээнд 4245 болж шинээр тодруулсан 988 газар зүйн нэрийн хувийн хэрэг хөтөлж, УИХ-аар батлуулах хүсэлтийн маягтыг бэлэн болгоод байна. Сум тус бүрийн тайланд дүгнэлт гаргасан. 2023 онд Баянжаргалан, Хулд сумын газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах ажилд шаардагдах төсвийг гарган ажлын даалгаврыг батлуулан тус сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтад оруулах саналыг хүргүүлээд байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 38 | Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын нэгж, түүний удирдлагын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Геодези үураг зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэгт заасныг үндэслэн засаг захиргааны нэгж болох багийн оноосон нэрийг Монгол Улсын Их Хурлын тогтоолоор батлуулах ажлыг зохион байгуулахад | | Хамтран ажилласан мэдээлэл, биелэлтийн тайлан. | Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Геодези зураг зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нутаг дэвсгэрийн хэмжээнд засаг захиргааны нэгж болох багийн оноосон нэрийг Монгол Улсын Их Хурлын тогтоолоор батлуулах ажлын тандан судалгаа, холбогдох баримт мэдээлэл бүрдүүлэх нөхцөл хангагдсан байна. | Багийн оноосон нэрийг Улсын Их Хурлын тогтоолоор батлуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт ГХБХБГ-ын Геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн орсон. 2022 оны 09 дүгээр сард ажлын хэсгийн анхны хурал зохион байгуулагдаж аймгийн зүгээс шаардлагатай мэдээллийг өгсөн. Анхны хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу 68 багийн нэр болон дугаарыг тулган шалгах ажлыг зохион байгуулан 4 сумын 13 багийн нэр болон дугаар зөрүүтэй байсныг засварлуулах саналаа |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | оролцох, хамтарч ажиллах, холбогдох ажлын хэсэгт орж ажиллах. | | | 11.8 дахь хэсгийг хэрэгжүүлж ажилласан байна. | | албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Мөн шинэчилсэн жагсаалтыг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 01/1475 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 39 | Газрын харилцааны салбарын баримтыг цахимжуулах, хадгалах, хамгаалах, архивын стандарт орчныг бүрдүүлэн ажиллахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн төсвийг жил бүр орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэх. | | Батлагдсан төсвийн хэмжээ | Архивын стандарт орчин сайжирсан байна. | Шаардлагатай тоног төхөөрөмжийн хангагдсан байна. | 2022 онд газрын харилцааны салбарын баримтыг цахимжуулах, хадгалах, хамгаалах ажлын хүрээнд шаардлагатай 10,6 сая төгрөгийн 3 принтер, 5 скайнер, архивын өрөөнд шинээр 2 ширхэг нягтруулсан шүүгээг 6,800,000 төгрөгөөр худалдан авч албан хэрэгцээнд ашиглаж байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 40 | Сумдын газрын даамалд хадгалагдаж байгаа нэгж талбарын хувийн хэргийн баримтыг аймгийн ГХБХБГ-ын байгууллагын архивт татан төвлөрүүлэхэд шаардлагатай санхүүгийн асуудлыг шийдвэрлэн, дэмжлэг үзүүлэх. | | Бүх сумын нэгж талбарын хувийн хэрэг | Баримтын хадгалалтын орчин бүрдсэн байна. | Баримтын хадгалалт, хамгаалалт сайжирна. | Тус байгууллагын архивын өрөөний шалыг нь бетондож, 1 сая төгрөгийн засвар хийсэн. Мөн архивын нягтруулсан 6 ширхэг шүүгээг 14,8 сая төгрөгөөр авч угсарч байршуулсан ба архивын өрөөг стандартын дагуу тохижуулж баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулсан. Тус онд 2003-2010 онд сумдад үүссэн өмчлөлийн газрын нэгж талбарын хувийн хэргийг хүлээн авсан бөгөөд 14 сумын 3949 хувийн хэргийн татан авч төвлөрүүлээд байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 41 | Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах, | | 1 | Хууль хэрэгжсэн | Төрийн болон албаны нууцын хадгалалт, | Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах талаар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | холбогдох хууль журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой хийгдэж байгаа ажилд хяналт тавих заавар зөвлөмж өгөх. | | | байна. | хамгаалалт сайжирсан байна. | хийгдсэн ажлын 2021 оны мэдээг 2022 оны 01 дүгээр сард хүргүүлсэн. Газрын даамлуудыг чадавхжуулах сургалт болон байгууллагын хуулийн цагаар 19 албан хаагчдад төрийн болон албаны нууцыг хадгалах тухай заавар зөвлөмжийг өгч ажилласан. 2022 оны мэдээг 2023 оны 1 дүгээр сард хүргүүлнэ. **Хэрэгжилт: 100** |
| **Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр** | | | | | | |
| 42 | Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх. | | 1. Үйл ажиллагаа явуулж буй Сууц өмчлөгчдийн холбооны тоо:<br>2. Сууц өмчлөгчдийн холбоодод гэрээгээр ашиглуулж буй орчны газрын хэмжээ, га<br>3. Дундын өмчлөлийн эд хөрөнгийн засварт зориулж орон нутгийн төсөв, орон нутгийг хөгжүүлэх | Холбогдох 7 заалт хэрэгжсэн байх. | Хуулийг хэрэгжүүлэх, хагас, бүтэн тайлагнаж ажилласан байна. | Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн холбогдох 7 заалтын хэрэгжилтийг гаргаж ГХБХБГ-ын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 1/456 тоот албан бичгээр БХБЯаманд хүргүүлсэн.<br>2020 оны 12 сард Сайнцагаан сумын иргэдийн бүх нийтийн хурлын шийдвэрээр “Говь сервис” СӨХ-г байгуулан, тус сумын Засаг дарга бөгөөд Мандалговь хотын захирагчийн 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар захирамжаар холбоог бүртгэсэн. 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Сайнцагаан сумын ИТХ-ын 09 дугаар тогтоолоор 7.37 га эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Энэ онд тус “Говь сервис” СӨХ-ны |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | сангаас шийдвэрлүүлсэн хөрөнгө, сая төгрөгөөр: 4. СӨХ-дын үйл ажиллагаанд нь аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулсан байдал | | | үйл ажиллагааны талаар холбооны гишүүдийн хүсэлтээр болон шаардлагатай бол санаачлагаараа холбооны үйл ажиллагаанд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар хяналт, шалгалт хийлгэж, дүгнэлт гаргуулах хүсэлт ирүүлээгүй байна. СӨХ-дын үйл ажиллагаанд нь аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах хуулийн хугацаа болоогүй байна. “Говь сервис” СӨХ-ны үйл ажиллагааг дэмжин, хамтран ажиллаж байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 43 | Шинээр ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны байшинд хамаарах инженерийн түгээх сүлжээг орон нутгийн өмчид бүртгэж авах, шугам сүлжээний ашиглалтыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад хариуцуулах ажлыг шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулах. | | Орон нутгийн өмчид бүртгэгдсэн түгээх сүлжээ, у/м, | Түгээх сүлжээг орон нутгийн өмчид бүртгэж, ашиглалтыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад хариуцуулсан байх. | Хэрэгжилтийг зохион байгуулж, хагас, бүтэн жилээр тайлагнаж ажилласан байна. | 2022 оны жилийн эцсийн байдлаар ашиглалтад орсон нийтийн зориулалттай 6 орон сууцны барилгын инженерийн түгээх сүлжээг орон нутгийн өмчид бүртгэж авах, шугам сүлжээний ашиглалтыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад хариуцуулах ажлыг зохион байгуулсан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 44 | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйл, 17, 18, 19 дүгээр зүйлд заасан заалтуудыг хэрэгжүүлэх. | - | Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг 70 хувьд хүргэнэ. | Хууль, тогтоомжийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлснээр тусгай зөвшөөрөл бүхий ус хангамж, | 1. Дундговь аймгийн Сайнцагаан суманд шинээр цэвэрлэх байгууламж ашиглалтад орсон байна. 2. Дэвшилтэт техник, технологи бүхий шинэ цэвэрлэх | 1. “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-ийн 8, 17, 18, 19 дүгээр зүйлийн аймагт хэрэгжүүлсэн ажлын тайланг гаргаж ГХБХБГ-ын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 1/457 тоот албан бичгээр БХБЯаманд хүргүүлсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 70 хувьд хүргэнэ. | ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний байгууллагын хэвийн найдвартай тасралтгүй үйл ажиллагаа хангагдсан байх. Иргэдийг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн усаар хангасан байх. | байгууламжид ажиллах инженер, техникийн ажилтан, ажиллах хүчийг барилга байгууламжийг эхлэхээс дуусталх бүх шатанд дадлагажуулах, заалтыг тус тус хэрэгжүүлсэн байна.<br>3. Инженер, техникийн ажилтан, ажиглагсдын тогтвор суурьшилтай, хариуцлагатай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.<br>4. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулсан байна.<br>5. Ус хангамжийн эх үүсвэрийн байгууламжид унд ахуйн усыг халдваргүйжүүлэх төхөөрөмжийг орон нутгийн хөрөнгөөр суурилуулсан байна.<br>6. Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг газрын | 2. Аймгийн төвд хоногт 3000м3 хүчин чадал бүхий биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж 2022 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан. Цэвэрлэгээний түвшин 97 хувь байна.<br>3. Шинээр хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлуудтай холбогдуулан инженер техникийн ажилчдыг сонгон шалгаруулалтад оруулж ажилд авах, цаашид тогтвор суурьшилтай ажиллах талаар анхаарч мөн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг бүрэн хангасан ажлын байр бий болгох эрсдлийн үнэлгээ хийлгэж, төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллах, инженер техникийн ажилчдын ХАБЭА-н талаарх мэдлэгийг сайжруулах чадавхжуулах сургалтад хамруулсан.<br>4. Ус хангамжийн эх үүсвэрт ус халдваргүйжүүлэх төхөөрөмж суурилуулах талаар хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох газарт хандсан.<br>5. Ус хангамж, ариутгах татуургын системийн холбогдолтой байгууламжууд инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг газрын кадастрын мэдээллийн санд бүрэн оруулсан.<br>6. Аймгийн хэмжээнд инженерийн шугам сүлжээний хамгаалалтын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | кадастрын мэдээллийн санд оруулсан байна.<br>7. Монгол Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хүн амын унд, ахуйн усны чанарын асуудлыг бодлогын түвшинд авч үзэн, хэрэгжүүлэх. | зурвасыг газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн санд оруулсан.<br>7. Монгол Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд аймгийн төвийн ундны эх үүсвэрт шинээр гүний худаг гаргах ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 245,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Топдриллинг” ХХК гүйцэтгэж байна.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 45 | УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 6.2.7-д “Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, “Сумдын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлэх. | | 1 сум, сумдын гэр хорооллын айл өрхийн 10-аас доошгүй хувь | Холбогдох хууль тогтоомж, норм, стандартын дагуу | 1. Төвлөрсөн шугам сүлжээтэй сумдын гэр хорооллын айл өрхийн ус, дулаан, ариутгах татуургын шугам сүлжээнд холбосон байна.<br>2. “Сумын хөгжил” төслийн хүрээнд 1-2 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан байна. | 1. Азийн Хөгжлийн Банкны зээлийн санхүүжилттэй Эрдэнэдалай сумын төвийн 50м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, ус хангамж, ариутгах татуургын шугамын барилга угсралтын ажлыг “Сайн констракшн” гүйцэтгэж 2022 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан. Тус сумын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагууд, төрийн байгууллагууд шугам сүлжээнд холбогдсон.<br>“Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл” тус аймгийн Луус суманд хэрэгжиж байгаа бөгөөд гүйцэтгэгчээр “Бурхант хясаат” ХХК 3,995.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. Тус онд хоногт 50м$^3$ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэвэрлэх байгууламжийн бетон цутгалтын ажил, био цөөрөм, гүний худаг, усан сангийн байгууламж, ус түгээх байрны ажлууд хийгдсэн. Ажлын явц 25 хувьтай, он дамжин хэрэгжинэ.<br>2. “Сумын хөгжил” төслийн хүрээнд сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөд тусгуулан ажиллаж байна. Тус онд Баянжаргалан, Луус, Өндөршил сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хүлээн авсан.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 46 | Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах. | | 1. Ундны усны судалгаа, ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд хамрагдсан сумын тоо:<br>2. Ундны усны мэдээллийн санд бүртгэгдсэн усны эх үүсвэрийн тоо | Хүн амын ундны усны чанарын судалгаа хийгдэж, ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө хангагдсан байна. | 1. Аймгийн хэмжээнд сумдын усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулан баталсан байна.<br>2. Сумдын ундны усны чанарын судалгааг хийлгэсэн байна. | 1. Тус аймгийн Засаг даргын 2018 оны захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг “Мандалговь хотын ундны усны аюулгүй байдлыг хянах үйл ажиллагааны хяналт шинжилгээний төлөвлөгөө”-г батлуулан, 84 хувьтай хэрэгжүүлсэн.<br>2022 онд тус аймаг дахь Төрийн аудитын газраас “Ундны усны чанар, аюулгүй байдал, хэрэгцээ, хангамжийн талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийгдэн хлоржуулалтын станцын ажиллагааг хэвийн болгож ундны усны эх үүсвэрийг ариутгах ажлыг зохион байгуулж, нянгийн тоог бууруулан хяналт тавьж |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллах, ундны усны шингжилгээг дотооддоо хийх лабораторийг ашиглалтад оруулах, усны олборлолтын нарийн хэмжиж хэрэглэгчдийн усны хэрэглээнд хяналт тавьж ажиллах, цэвэрлэх байгууламжийн саарал усыг аймгийн төвийн мод усалгаа, дулаан үйлдвэрлэл, зам барилгын ажилд дахин ашиглах зөвлөмж өгсөн.<br>2. Тус аймгийн Мэргэжлийн хяналтын газраас нийт 80 ундны усны худагт чанарын шинжилгээг хийж, лабораторийн шинжилгээний дүнг нэгтгэн, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.<br>**Хэрэгжилт: 70 хувь** |
| 47 | Орон нутгийн өмчит нийтийн аж ахуйн байгууллагуудын зардал нөхөх төлөвлөгөөг хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй хамтран боловсруулж, хэрэгжүүлэх. | | 1 багц | Хангагч байгууллагын санхүүгийн тайлан алдагдалгүй болсон байна. | Зардал нөхөх төлөвлөгөө батлагдсан байна. | “Дундговь-Ус” ОНӨААТҮГ нь “Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс баталсан үнэ тарифыг мөрдөн ажилладаг бөгөөд 2022 онд санхүүгийн тайлан алдагдалгүй ажилласан.<br>“Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 2 дугаар тогтоолоор “Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын дунд хугацааны бизнес төлөвлөгөө, хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг баталсан. Дээрх тогтоолын дагуу зардал нөхөх төлөвлөгөөг “Дундговь-Ус” ОНӨААТҮГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулан баталсан. Уг төлөвлөгөөг 2023 оноос эхлэн хэрэгжүүлэнэ.<br>**Хэрэгжилт: 90 хувь** |
| 48 | Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.11-д “Нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн засаг дарга шийдвэрлэх”-ээр заасан хуулийн заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах. | 85.0 | Стандартын шаардлага хангахгүй нүхэн жорлонгийн тоог 10 хувиар буруулсан байна. | “Нүхэн жорлон угаадасны нүх. Техникийн шаардлага, MNS 5924: 2015” стандартын шаардлагад нийцсэн байх. | 1. Аймгийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тооллого зохион байгуулж, мэдээллийн сан үүсгэж үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.<br>2. Судалгаанд үндэслэн “Нүхэн жорлон угаадасны нүх. Техникийн шаардлага. MNS 5924: 2015” стандартын шаардлагад нийцсэн жорлонг суурилуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.<br>3. Хэрэгжилтийн мэдээ, тайланг хагас, бүтэн жилээр ирүүлсэн байна. | 1. 2020 онд аймгийн төв болон 14 сумын төвийн хөрс бохирдуулагч нүхэн жорлон, угаадасны нүхний тооллого явуулж мэдээллийн сан үүсгэсэн. Жил бүр мэдээллийн санд баяжилт хийж байна.<br>2. Тус судалгааг үндэслэн “Хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах” төлөвлөгөө боловсруулан, аймгийн Засаг даргын тамгын газраар батлуулан, төлөвлөгөөний дагуу аймгийн ОНХС-ийн хөрөнгөд 85,0 сая төгрөг батлуулан эхний ээлжинд улсын чанартай авто замын дагуу болон цэцэрлэгт хүрээлэн, наадмын талбай гэх мэт олон нийтийн газрууд 36 ширхэг сайжруулсан ариун цэврийн байгууламж байрлуулсан.<br>**Хэрэгжилт:90 хувь** |
| 49 | Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг хэрэгжүүлэх | | 1 багц | “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага. | Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар сольсон байна. | Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажил тус аймгийн 3 суманд хэрэгжсэн. Үүнд:<br>Цагаандэлгэр сумын сургууль, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | MNS 4943:2015” стандартын шаардлага хангаж ажилласан байна. | | цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн ажлыг “Мөнхийн үргэлжлэл” ХХК гүйцэтгэж 2022 оны 11 дүгээр сард, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн ажлыг “Винтер гарден” ХХК гүйцэтгэж 9 болон 11 дүгээр сард тус тус ашиглалтад оруулсан. Дээрх төслийг хэрэгжүүлснээр 3 сумын нийт багш сурагчид ая тухтай орчинд сурч, боловсрох нөхцөл бүрдсэн. Мөн дараагийн ээлжинд хамрагдах Адаацаг, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт, Луус, Өндөршил, Сайхан-Овоо Хулд зэрэг сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн зураг төслийг “Стийл прожект” ХХК-д боловсруулж байна.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 50 | АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжсэн “Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН 3388 нэмэлт санхүүжилтийн төсөл”-ийн хүрээнд хэрэгжиж буй ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах. | | 1 багц | “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага. MNS 4943:2015” стандартын шаардлага хангаж ажилласан байна. | 1. Дундговь аймгийн Сайнцагаан суманд шинээр цэвэрлэх байгууламж ашиглалтад орсон байна.<br>2. Дэвшилтэт техник, технологи бүхий шинэ цэвэрлэх байгууламжид ажиллах инженер, техникийн ажилтан, ажиллах хүчийг | 1. Аймгийн төвийн хоногт 3000м3 хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний барилга байгууламж, гэр хорооллын 5,57км бохир усны шугамын ажлыг “Сайн констракшн” ХХК гүйцэтгэж 2022 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан бөгөөд туршилт, тохируулгын ажил хийгдэж хэвийн ажиллаж байна.<br>2. Азийн хөгжлийн банк, Техник |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | барилга байгууламжийг эхлэхээс дуусталх бүх шатанд дадлагажуулах, мэдлэг, мэргэжлийг нь дээшлүүлж, мэргэшсэн ажилтнуудын нөөцтэй болсон байна.<br>3. Цэвэрлэх байгууламжийн ашиглалтын жилийн үйл ажиллагааны зардлын эх үүсвэрийг шийдвэрлэсэн байна.<br>4. Цэвэрлэх байгууламжид ажиллахаар мэргэшсэн ИТА болон гүйцэтгэх ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах. | технологийн коллежтэй хамтран тус цэвэрлэх байгууламжийн 2 инженерийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан.<br>3. Тус цэвэрлэх байгууламжийн ашиглалтын жилийн үйл ажиллагааны зардалд 2023 оны улсын төсвөөс 324.8 сая төгрөг төсөвлөхөөр шийдвэрлэгдсэн.<br>4. Цэвэрлэх байгууламжийн ашиглалт үйлчилгээг "Дундговь-Ус" ОНӨҮГ хариуцан ажиллаж байгаа бөгөөд ИТА 5, ээлжийн оператор 4, лаборант 1, химич 1, цахилгаанчин 1 нийт 12 ажилтантай ажиллаж байна.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 51 | "Гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх тухай" Засгийн Газрын 2012 оны 209 тоот тогтоолыг аймагт хэрэгжүүлэх. | | Аймгийн хэмжээнд | Хууль тогтоомжийн дагуу | Аймгийн гэр хорооллын иргэдэд ус түгээсэн усны орлого, зардлын зөрүүг тусгуулан батлуулсан байна. | "Гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх тухай" Засгийн Газрын 2012 оны 209 дүгээр тогтоолын дагуу 2022 оны орон нутгийн хөрөнгөд 80,0 сая төгрөгийг батлуулан, гэр хороололд амьдарч байгаа иргэдийн усны үйлчилгээний үнийн зөрүүг хангагч "Дундговь-Ус ОНӨААТҮГ-т олгосон.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 52 | Аймаг, сум, суурины инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга | - | Багц судалгаа-1 | Холбогдох хууль тогтоомжийн | Судалгаа, мэдээллийг БХБЯ-нд ирүүлсэн байна. | Барилга, хот байгуулалтын яамны барилгын нэгдсэн мэдээллийн санд дулаан хангамжийн эх |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгууламж, шугам сүлжээний /ус, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, халаалтын зуух, үерийн хамгаалалтын далан, суваг г.м/ тоо хэмжээ, хүчин чадал, ашиглалт, үйлчилгээний түвшингийн өнөөгийн байдлыг /чанар, насжилтыг/ тодорхойлсон судалгаа, мэдээллийг БХБЯ-ны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ирүүлэх. | | | дагуу ба судалгаа үнэн бодит байх. | | үүсвэр, дулаан хангамжийн шугам сүлжээ, усны эх үүсвэрийн судалгаа, ус хангамжийн шугам сүлжээ, ус түгээх байр, цэвэрлэх байгууламжийн судалгаа, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн судалгаа, цахилгаан хангамжийн шугам сүлжээний судалгаа, холбооны шугам сүлжээний судалгаа, инженерийн бэлтгэл арга хэмжээний судалгаа, нийтийн халуун усны судалгаа, бага оврын халаалтын зуухны судалгаа гэх мэт аймгийн хэмжээний нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн 23 төрлийн судалгааг маягтын дагуу мэдээллийн санд тухай бүр оруулсан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 53 | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр аймаг, сумдад шинээр болон шилжиж хийгдэхээр тусгагдсан инженерийн хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт, үерийн хамгаалалтын далан, сувгийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ажлын үр дүнг тайлагнах. | | Ашиглалтад оруулсан шугам, сүлжээний урт, инженерийн байгууламжийн тоо | Холбогдох хууль тогтоомж, норм, стандартын дагуу | Инженерийн хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна. Аймаг бүрд иргэдийг орон сууцжуулах төсөл хэрэгжих, хүн амын ажиллаж, амьдрах таатай нөхцөл, хот, суурин газар өргөжин тэлэх боломж бүрдсэн байна. Ажлын үр дүнг тайлагнасан байна. | Азийн Хөгжлийн Банкны зээлийн санхүүжилттэй Эрдэнэдалай сумын төвийн 50м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний “Сайн констракшн” гүйцэтгэж 2022 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан.<br>Сайхан-Овоо сумын усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн дуусгалын ажлыг “Алтайн үндэс констракшн” ХХК гүйцэтгэж, 2022 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл” тус аймгийн Луус сумын төвд хэрэгжиж байгаа бөгөөд гүйцэтгэгч “Бурхант хясаат” ХХК 3,995.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж тус онд 50м3 цэвэрлэх байгууламжийн бетон цутгалтын ажил, био цөөрөм, гүний худаг, усан сангийн байгууламж, ус түгээх байрны ажлууд хийгдсэн. Ажлын явц 25 хувьтай, он дамжин хэрэгжинэ.<br>Дээрх ажлуудад захиалагчийн хяналтын тухай бүрт гүйцэтгэж тайланг БХТ-д хүргүүлсэн.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 54 | Инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээг хариуцах тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагыг төсөл, арга хэмжээ эхлэх үеэс тогтоох, хүлээлгэн өгөх, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах. | | Ашиглалтад оруулсан шугам, сүлжээний хүчин чадал (урт метр) | Холбогдох хууль тогтоомжийн дагуу байх | Инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний ашиглалт, хамгаалалт, хэвийн ажиллагаа хангагдаж, үйл ажиллагаа, үйлчилгээ сайжирсан байна. | Тус аймгийн 14 сум дулаан хангамжийн нэгдсэн сүлжээнд холбогдсон бөгөөд ашиглалт, үйлчилгээг мэргэжлийн байгууллагууд хариуцан хэвийн ажиллаж байна. Аймгийн төвийн 3000$м^3$/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлэх үеэс ашиглалт үйлчилгээг “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-т хариуцуулахаар угсралтын ажлын явцад инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг сурган, 2022 оны 10 дугаар сараас тус байгууллага ашиглалт үйлчилгээг хэвийн хариуцан ажиллаж байна.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 55 | Инженерийн дэд бүтцийн | | Аймгийн | Холбогдох | Аймгийн хэмжээнд | Орон нутгийн төсвийн 150,0 сая |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэл хийх, боловсронгүй болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах. | | хэмжээнд | хууль, дүрэм, журам, стандарт, төлөвлөлт, ажлын даалгавар, ажлын гүйцэтгэлийн дагуу хийгдсэн байх | “Байр зүйн дэвсгэр тоон зураг, дэд бүтцийн мэдээллийн сан” болон “Хот байгуулалтын мэдээллийн сан”-д хот суурин газруудын газар дээрх болон доорх инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний мэдээллээр тогтмол баяжилт хийх ажлыг зохион байгуулсан байна. | төгрөгөөр “Дундговь аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлж, мэдээллийн санд бүртгэх” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд аймгийн төвөөс бусад 14 сумын 20,9км дулаан хангамжийн шугам, 21,19км ариутгах татуургын шугам, 655 ширхэг цооног, 18,83км ус хангамжийн шугам, 149,22км цахилгаан хангамжийн шугам, 3281 ширхэг тулгуур, 48 дэд станцын зураглал мэдээлэл бүрэн хийгдэж “Байр зүйн дэвсгэр тоон зураг, дэд бүтцийн мэдээллийн сан” болон “Хот байгуулалтын мэдээллийн сан”-д баяжилт хийгдсэн.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 56 | Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг мэдээллийн санд оруулж, мэдээллийн сангуудыг нэгтгэж, хамгаалалтын зурваст газар олгохгүй байх ажлыг зохион байгуулах. | - | Орон нутгийн өмчид шинээр бүртгэсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээний урт | Хамгаалалтын зурвас газар олгохгүй байх | Хэрэгжилтийг зохион байгуулж, хагас, бүтэн жилээр тайлагнаж ажилласан байна. | Аймгийн хэмжээнд 2219806 $м^2$ цэвэрлэх байгууламж 25840.5м цахилгаан, 156766.8м холбооны, 31638м дулаан хангамжийн шугам, 64250м цэвэр усны шугам, 11545м урт бохир усны шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн санд оруулсан. Хамгаалалтын зурваст газар олголт хийгдээгүй болно.<br>Хэрэгжилтийг ГЗБГЗЗГ-ын даргатай байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтээр хагас болон бүтэн жилээр тайлагнасан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хэрэгжилт: 100 хувь** |
| 57 | Аймаг, сумдын эрчим хүчний хэрэглээ /цахилгаан, дулаан, хангамж/-ний өнөөгийн байдал, хүчин чадал, цаашдын төлөвлөлтийн талаарх нарийвчилсан судалгаа гаргаж, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний саналыг боловсруулж, ирүүлэх. | - | Орон нутгийн өмчид шинээр бүртгэгдсэн гэрэлтүүлгийн хэмжээ, кабель шугам | Төслийн хүрээнд бий болсон барилга байгууламжийг орон нутгийн өмчид бүртгэж, ашиглалтыг мэргэжлийн байгууллагад хариуцуулсан байх. | Хэрэгжилтийг зохион байгуулж, хагас, бүтэн жилээр тайлагнаж ажилласан байна. | Тус аймгийн төв болон 14 сумын эрчим хүчний хэрэглээ /цахилгаан, дулаан, хангамж/-ний өнөөгийн байдал, хүчин чадлын талаарх нарийвчилсан судалгааг гаргаж ГХБХБГ-ын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 2/146 тоот албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. Тус аймгийн Эрдэнэдалай суманд улсын төсвийн 217,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 км хатуу хучилттай авто замын гэрэлтүүлэг, Сайнцагаан суманд орон нутгийн хөгжлийн сангийн 154 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2,4 км хатуу хучилттай авто замын гэрэлтүүлгийн ажлыг тус тус ашиглалтад оруулж, өмчлөгч байгууллагад шилжүүлэн өгсөн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| **Иргэдийг орон сууцжуулах чиглэлээр** | | | | | | |
| 58 | Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолын дагуу “Улс орон нутгийн төсөв, гадаад, дотоодын зээл, буцалтгүй тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө”-өөр баригдсан түрээслэх, түрээслүүлээд өмчлүүлэх зориулалт бүхий орон сууцанд зорилтод бүлгийн иргэдийг хамруулах хүрээнд тухай бүр иргэдийн хүсэлтийг авч, холбогдох | - | Орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сангийн хүчин чадалд тулгуурлах. | Иргэдийн хүсэлтийг шуурхай, нээлттэй, холбогдох журмын дагуу шийдвэрлэсэн байх. | Зорилтод бүлгийн иргэд түрээслэх, түрээслүүлээд өмчлөх орон сууцанд хамрагдсан байна. | Тус аймгийн хэмжээнд гадна инженерийн шугам сүлжээг улс, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн орон сууцны хороололд шинээр баригдах орон сууцны барилгын нийт талбайн 2 хувийг орон нутгийн өмчид шилжүүлэн авах замаар орон нутгийн өмчит түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх хөтөлбөрийг боловсруулж, аймгийн ИТХ-ын 2021 оны 05 дугаар сарын 05-ны |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | журмын дагуу нээлттэй, ил тод шийдвэрлэж ажиллах, улирал бүр тус яаманд тайлан, мэдээ ирүүлэх. | | | | | өдрийн 03 дугаар тогтоолоор батлуулсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус аймгийн Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт 4.3га газарт “Түмний хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг хийлгэж, 2022 оны БХБСайдын багцад “Түмний хороолол”, “Хаус хороолол”-ын гадна бохир усны шугамын ажлын 800 сая төгрөгийг батлуулан, барилгын угсралтын ажлын гэрээ байгуулан ажиллаж байна. **Хэрэгжилт: 0 хувь** |
| 59 | Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн дэд бүтцийн ажил хийгдсэн, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний хүрээнд орон сууцны хороолол барих боломжтой газруудыг орон нутгийн өмчид авч, орон сууцны хороолол барих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-тай хамтран ажиллах, санал боловсруулах холбогдох тооцоо, судалгааг боловсруулах, урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулах. | - | Төсөл, газрын сангийн тоо, ТЭЗҮ | Инженерийн дэд бүтэцтэй орон нутгийн өмчийн газрын мэдээлэл | Зорилтод бүлгийн иргэдэд чиглэсэн орон сууцны хороолол барих боломж бүхий газрыг өмчлөлд авч, холбогдох тооцоо, судалгаа, ТЭЗҮ-ийг боловсруулсан байна. | Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлагдсан "150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөр (2019-2023)-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус аймгийн Сайнцагаан сумын 7 дугаар багт орон сууцны хороолол барихаар төлөвлөж буй 2 газрын байршлын мэдээлэл, инженерийн дэд бүтцийн ажилд шаардагдах төсөв, хөрөнгийн мэдээллийг гаргаж БХБЯ-нд хүргүүлсэн. Мөн Сайнцагаан сумын 7 дугаар багт 4,3 га газарт “Түмний хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг, төсвийг боловсруулсан бөгөөд тус газрыг орон нутгийн өмчлөлд авсан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 60 | Улс, орон нутгийн төсөв, | - | Орон нутгийн | Холбогдох | Орон нутгийн хэмжээнд | Тус аймгийн хэмжээнд гадна |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлэх. Улирал бүр тус яаманд тайлан, мэдээлэл ирүүлэх. | | өмчийн түрээсийн орон сууцны сан нэмэгдсэн байна. | хууль өмчийн түрээсийн орон сууцны сан нэмэгдсэн байна. | улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан нэмэгдэж, зорилтот бүлгийн иргэд орон сууцаар хангагдах боломж хангагдсан байна. | инженерийн шугам сүлжээг улс, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн орон сууцны хороололд шинээр баригдах орон сууцны барилгын нийт талбайн 2 хувийг орон нутгийн өмчид шилжүүлэн авах замаар орон нутгийн өмчит түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх хөтөлбөрийг боловсруулж, аймгийн ИТХ-ын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлуулсан. Тус онд Сайнцагаан сумын 9 дүгээр багт хувийн хөрөнгө оруулалтаар 6 айлын инженерийн бүрэн хангамжтай түрээсийн байр баригдсан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 61 | Гэр хорооллын газрын дахин зохион байгуулах бүтцийн нэгжийг байгуулж, орон нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан амины орон сууц барих бүсүүдийг тодорхойлж, эхний ээлжийн байршлыг нарийвчлан тогтоож, ИТХ-аар батлуулах. | - | Батлуулсан байршлын тоо, үйл ажиллагааны явц. | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангаар баталгаажуулна. | Амины орон сууц барих бүсүүдийг нарийвчлан тогтоож, ИТХ-аар батлуулсан байна. | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр батлагдсан Мандалговь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан Сайнцагаан сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт “Хаус хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг батлан, зураг төслийн байгууллагад хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 62 | Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, ашиглалтын шаардлага | - | Төслийн хүрээнд ашиглалтад орсон орон | Хууль тогтоомж норм ба дүрэм, стандартын дагуу баригдсан | Гэр хорооллын барилгажилт эрчимжсэн, шаардлагатай хөрөнгө | “Стийл лайн” ХХК-ний боловсруулсан Сайнцагаан сумын Айраг багийн 9-р гудамжны тохижилтын зургийн дагуу MNS |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хангахгүй орон сууцыг буулган дахин барилгажуулах төслийн ажлыг эрчимжүүлэх, төсөлд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, хамтран ажиллах. | | сууцны тоо | байх. | оруулалт, эдийн засгийн үр өгөөжийн тооцоо судалгаа гарсан байна. | 6877:2020 стандартад нийцүүлэн дээрх гудамжны тохижилтын ажлыг хийгдэж байна.<br>Энэ онд инженерийн дэд бүтцийн тохижилтын ажлыг ОНХС-ийн 199,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Дундговь-Ус” ОНӨҮГ гүйцэтгэж байна. Инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ тавигдсанаар гэр хороолол барилгажих нөхцөл бүрдэнэ.<br>Мөн тус аймгийн Сайнцагаан сумын 7 дугаар багт ашиглалтын шаардлага хангахгүй 1 барилгыг буулган шинээр 20 айлын орон сууцны барилгыг хувийн хөрөнгө оруулалтаар барьж 2022 оны 12 дугаар сард ашиглалтад оруулна.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 63 | Ипотекийн зээлд амины орон сууцны хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Барилгын хөгжлийн төвийн захирлын 2021 оны А/238 дугаар тушаалаар батлагдсан “амины орон сууцны барилгын ажилд захиалагчийн техник хяналтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.1.5-д заасан баримт бичгийн бүрдэл, тодорхойлолт, холбогдох бусад шаардлагатай мэдээллээр иргэд болон барилга хөгжлийн төвийг | - | Тодорхойлолт авсан иргэдийн тоо, мэдээллээр хангагдсан иргэдийн тоо | Журмын хэрэгжилтэд тус тодорхойлолт-оос хамаарсан саатал үүсээгүй байх, иргэдээс гаргасан гомдолгүй байх. | Ипотекийн зээлээр амины орон сууц барих үйл ажиллагааг эрчимжүүлэх, бүс орон нутгийн иргэд ипотекийн зээлээр амины орон сууцтай болох мэдээллээр хангагдсан, идэвхжсэн байх. | Монгол Банкнаас авсан 2022 оны 12 дугаар сарын мэдээгээр 2,779,731,415 төгрөгийн орон сууцны ипотекийн зээлийг 58 иргэнд, 485,718,745 төгрөгийн амины орон сууцны зээлийг 8 иргэнд тус тус олгосон байна. Амины орон сууцны ипотекийн зээл олгогдоогүй байна.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тухай бүр шуурхай хангаж ажиллах, иргэдийг мэдээллээр хангаж ажиллах. | | | | | |
| 64 | Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын ашиглалтад тавих ерөнхий шаардлага MNS 6877:2020 стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллах | - | Аймгийн хэмжээнд | Стандарт хангагдсан байх | Амины орон сууцны зориулалттай газрын ашиглалт, нөхцөл сайжирсан байна. | “Стийл лайн” ХХК-ний боловсруулсан Сайнцагаан сумын Айраг багийн 9-р гудамжны тохижилтын зургийн дагуу MNS 6877:2020 стандартад нийцүүлэн дээрх гудамжны тохижилтын ажлыг хийгдэж байна.<br>Энэ онд дэд бүтцийн тохижилтын ажлыг ОНХС-ийн 199,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Дундговь-Ус” ОНӨҮГ гүйцэтгэж байна.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 65 | Газар хөдлөлт болон галд тэсвэртэй, хөрсний бохирдолгүй, ариун цэврийн болон эрчим хүчний хэмнэлттэй норм, дүрэм, стандартын шаардлага хангасан, тухайн орон нутгийн цаг уур, бүс нутгийн онцлогт тохирсон, хямд өртөг бүхий амины орон сууцны иж бүрэн нэг маягийн загвар зургийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-тай хамтран боловсруулж батлуулан, иргэдэд үнэ төлбөргүй ашиглуулах | - | 3-аас багагүй загвар зураг | Зурагт төсөл холбогдох норм, нормативт нийцсэн байх | Нэг маягийн загвар зураг боловсруулагдаж, иргэдэд хүрсэн байна. | Хямд өртөг бүхий амины орон сууцны иж бүрэн нэг маягийн загвар зураг төсөл “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т магадлалаар баталгаажсан бөгөөд уг зураг төслөөр 5 иргэнд үйлчилсэн.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 66 | Төрийн үйлчилгээг иргэдэд ойлгомжтой, чирэгдэлгүй | | Барилга, хот байгуулалтын | Төрөөс хэрэгжүүлж буй | Төрийн болон орон нутгийн өмчийн | Тус аймгийн хэмжээнд гадна инженерийн шугам сүлжээг улс, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хүргэх ажлын хүрээнд төрөөс хэрэгжүүлж буй түрээсийн орон сууцанд хамруулах журмыг бүс нутгийн хэмжээнд ялгаатай бусаар журамлах, нэгдсэн нэг шалгуур үзүүлэлтээр иргэдийг хамруулах хүрээнд холбогдох журам, баримт бичигт өөрчлөлт оруулах | | сайдын “Зорилтот бүлгийн иргэдийн түрээсийн орон сууцанд хамруулах” журмын төсөлд санал өгсөн байх | түрээсийн орон сууцанд хамрагдахыг хүссэн иргэн өмчийн ялгаатай байдлаас хамаарч нэмэлт баримт, бичиг иж бүрэн бүрдүүлдэггүй байх | түрээсийн орон сууцны журам бүс нутагт ялгаатай бусаар хэрэгжих | орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн орон сууцны хороололд шинээр баригдах орон сууцны барилгын нийт талбайн 2 хувийг орон нутгийн өмчид шилжүүлэн авах замаар орон нутгийн өмчит түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх хөтөлбөрийг боловсруулж, аймгийн ИТХ-ын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлуулсан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| **Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр** | | | | | | |
| 67 | Монгол Улсын Их хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 5 дахь заалт “орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгуудыг үе шаттайгаар бэхэлж | | Аймгийн хэмжээнд паспортжуулсан барилгын тоо, шаардлагатай тоног төхөөрөмжийн тоо | Холбогдох хууль, тогтоомж, норм, нормативын баримт бичгийн дагуу судалгааг гаргасан байна. | Тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Газар хөдлөлтөд тэсвэртэй хүчитгэх шаардлагатай барилга байгууламжийн судалгааг гаргаж шаардлагатай төсвийг шийдвэрлэж ажилласан байна. | Тогтоолын 5 дахь заалтын хүрээнд аймгийн хэмжээнд ашиглагдаж буй сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн орон сууцны барилгын судалгааг гаргасан бөгөөд судалгаагаар ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгаж, дахин төлөвлөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. 2022 оны улсын төсөвт 2 барилгыг буулгаж, шинээр барихаар хөрөнгийг батлуулсан. Үүнд: Сайнцагаан сумын 150 ортой 2 дугаар цэцэрлэгийн барилгын ажлыг "Энхбаялаг констракшн" ХХК 2,71 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд буулгалтын ажил хийгдсэн. Сайнцагаан сумын 640 суудалтай Хүмүүнлэг 3 дугаар сургууль, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хүчитгэх ажлыг зохион байгуулах”, паспортжуулахтай холбоотой багаж, тоног төхөөрөмж, техникээр хангах ажлыг зохион байгуулах | | | | | спорт заалны барилга угсралтын ажлыг "Си Эйч Би Жи констракшн" ХХК 9,54 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд буулгалтын ажил хийгдсэн. Дээрх 2 ажлын тухай жилийн гүйцэтгэл 100 хувьтай хэрэгжсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 68 | Барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах. Тухайлбал, барилгуудын “Архитектур төлөвлөлтийн даалгавар”-т “Барилгын дулаан хамгаалалтын норм”-ын шаардлагыг бүрэн хангасан байхаар болон “ногоон” барилгын үзэл баримтлалыг тусган хэрэгжүүлэх. | - | Арга хэмжээ - 5, эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй “ногоон” үзэл баримтлалыг тусгасан барилгын тоо | Барилгын тухай хуулийн 35.1.2 дахь заалт хэрэгжсэн байх. Эрчим хүчний хэмнэлттэй, “ногоон” технологи ашигласан байх | Орон сууцны болон бусад төрлийн барилгын норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэлт, чанар, аюулгүй байдал сайжирсан байна. | Аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын эх үүсвэр харгалзахгүйгээр бүх төрлийн барилга, байгууламжийн ажилд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж, барилгын норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар орон сууц, олон нийтийн зориулалттай 17 барилгын архитектур төлөвлөлтийн даалгаврыг Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм” болон холбогдох норм дүрмийн дагуу боловсруулж захиалагчид хүргүүлсэн бөгөөд тус даалгаварт барилгын дулаан хамгаалалт болон эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүч ашигласан байх талаар тусгаж, баталсан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 69 | Ашиглагдаж байгаа олон | | 1 тайлан | Үндсэн 45 | Аймгийн хэмжээнд | “Дундговь аймгийн хэмжээнд хот |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | нийт, иргэний болон үйлдвэрийн барилга байгууламжуудад шинэчилсэн байдлаар үзлэг, тооллого явуулах. | | (харьяа нутаг дэвсгэр дэх инженерийн хийцлэлтэй бүх барилга байгууламж) | үзүүлэлтээр, холбогдох дүрэм, журам, ажлын даалгавар, аргачлалын дагуу үнэн зөв (харьяа нутаг дэвсгэр дэх инженерийн хийцлэлтэй бүх барилга байгууламж) үндэслэлтэй байх | нэгдсэн тоог шинэчлэн гаргасан байна. | байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлж, мэдээллийн санд бүртгэх" зөвлөх үйлчилгээний ажлыг аймгийн төвөөс бусад 14 сумын төвийн барилга байгууламжид шинэчилсэн үзлэг, тооллого явуулсан. Үүнээс нийтийн зориулалттай орон сууц 79, худалдаа үйлчилгээний 282, төрийн үйлчилгээний 233, амины сууц 1151, сууцны бус зориулалттай 630, үйлдвэрийн зориулалтай 18, нийт 2393 барилга байгууламжийн мэдээллийг шинэчлэн бүртгэсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 70 | Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн хэрэгжилтийг хангуулж, аж ахуйн нэгж, байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг нэгдсэн хүснэгтээр гаргаж ирүүлэх. Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн | | 4 | Холбогдох хууль, дүрэм, норм, нормативын баримт бичгийг барилгын үйл ажиллагаанд мөрдүүлсэн байна. Уг ажлыг тоо баримттай, үнэн зөв тайлагнаж, ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээллийг маягтын дагуу ирүүлсэн байна. /харьяа нутаг | Хууль, тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Барилгын үйл ажиллагаанд норм, нормативын баримт бичгийг мөрдүүлсэн байна. | 2022 оны жилийн эцсийн байдлаар 37 барилга байгууламж, засвар, тохижилтын ажлыг 2022 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн дагуу комисс ажиллаж, Ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээллийг Барилга, хот байгуулалтын сайдын 55 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу гаргаж 4 дүгээр улирлын тайланг ГХБХБГ-ын 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/440 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын яам болон Барилгын хөгжлийн төвд тус тус хүргүүлсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ашиглалтын дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг ирүүлэх | | | дэвсгэр дэх барилга байгууламж/ | | **Хэрэгжилт: 100 хувь** |
| 71 | Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн хэрэгжилтийг хангуулан ажиллах, зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж, байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг нэгдсэн хүснэгтээр гаргаж ирүүлэх. | - | 4 | Холбогдох мэдээллийн санд тулгуурласан байна. /Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан/. Уг ажлыг тоо баримттай, үнэн зөв тайлагнаж, зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээллийг маягтын дагуу ирүүлсэн байна. /харьяа нутаг дэвсгэр дэх барилга байгууламж/ | Тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Уг ажлыг тоо баримттайгаар, бодитой тайлагнаж, улсын болон хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй болон ашиглалтад орсон барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон талаарх тайланг нэгтгэж ирүүлсэн байна. | “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн дагуу 2022 оны жилийн эцсийн байдлаар 22 барилга байгууламж, 7 засварын ажилд шинээр барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон. Тайланг Барилга, хот байгуулалтын сайдын 55 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу гаргаж 4 дүгээр улирлын тайланг ГХБХБГ-ын 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/440 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
